



209 Page




210 Page



211 Page



212 Page



213 Page

Даниел

- Daniel-

Тайлбарлагч Небухаднезар хаан үхээд, Дариус хаан Вавилоныг захирч байх үед болсон явдал ажээ. Дариус хаан боолчлогдон ирсэн хүмүүс дундаас мэргэн ухаантай, зан чанар сайтай Даниелыг сонгон сайд болгожээ. Гэтэл бусад сайд түшмэлүүд Даниелд дургүй байлаа. Тэд Даниелын сул талыг олж хорлох гэж оролдовч түүнд сул тал байхгүй байлаа.

Түшмэл1 Угүй нээрээ, ямар хүн гэхээрээ ийм байдаг байна аа. Царайлаг, ухаантай, нямбай, шудрага.

Түшмэл2 Хүүе чи Даниелын фэн юм уу? Яагаад түүнийг магтаад байгаа юм бэ? Надад нэг сайхан санаа байна. Тэр бол...

Түшмэл 1 “Хаантан минь, энэ улсад танаас өөр хэн нэгэнд мэргж үйлчилсэн хүн байна”
“Цаашид гучин өдрийн турш зөвхөн хаан танд л мэргж үйлчилнэ гэсэн хуулийг баталж өгнө үү”
Хаанаас өөр ямар ч бурхдад мэргж үйлчилсэн хүн байвал тэр хүнийг арслангийн агуй уруу шидэх шийтгэл өгье”

Тайлбарлагч Дариус хаан, шинэ хуулийг зөвшөөрч тамгаа даржээ. Тэгээд хааны элч нар шинэ хуулийг бүх ард түмэнд зарлав. Даниел, энэ хуулийг сонссон ч гэсэн өдөр бүр гурван удаа Бурханд өвдөг сөгдөн залбирч байлаа.

Түшмэл 1 Хаха ха, би юу гэж хэллээ. Хм Хм, хаантан минь улсын хуулийг зөрчиж Бурханд хандан залбирч мөргөсөн Даниелыг арслангийн агуй уруу шидэгтүн”


Тайлбарлагч Хаан Даниелд маш сайн ханддаг байсан боловч хуулийг зөрчсөн учир яаж ч чадалгүй арслангийн агуй уруу хийхийг тушаав. Тэгээд хаан, Даниелд ингэж хэлжээ.

Хаан “Чиний хүндэлж мөргөдөг Бурхан чамайг аврах болтугай”


Тайлбарлагч Даниел арслангийн нүхнээс Бурхан уруу хандан залбирч байв. Харин хаан Даниелд санаа зовон хоол ч идэж чадахгүй, шөнө нь унтаж ч чадахгүй байв. Өглөө болмогц, хаан эртлэн босож арслангийн нүх уруу явав.

Хаан “Даниел аа, Даниел аа! Чиний Бурхан чамайг хамгаалсан уу?

Даниел “Хаантан минь, Бурхан тэнгэр элч наараа илгээн арслангийн амыг хааж өглөө”



214 Page



215 Page

Тайлбарлагч Арслангийн нүхэнд Даниел маш тайван харагдаж байлаа. Өлсгөлөн арслангууд Даниелийн хажууд байгаа харагдана. Хаан маш их баярлажээ. Тэгээд Даниельыг гүтгэсэн хүмүүсийг олж илрүүлээд, тэднийг гэр бүлийнхэнтэй нь хамт арслангийн нүхэнд шидчихжээ.

Түшмэл1 Aaa.. Aaaa, aaaa aa.....Хаантан биднийг өршөөгөөч

Түшмэлүүд Aaaaaaa!

Тайлбарлагч Ийнхүү Хаан ард түмэндээ хандан Даниельн итгэдэг Бурханыг магтан хүндлэх тушаалыг буулгажээ. Даниел насан туршдаа Бурханд итгэн, Түүнд итгэмжтэй байж, амар тайван амьдарчээ.